



Хэвлэлийн мэдээ
2017 оны 6-р сарын 9

Холбогдох утас:
9710-9009

АмЧамын Америк руу хийх бизнес айлчлалд 20 гаруй төлөөлөгч оролцоно

УЛААНБААТАР, Монгол улс - Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (АмЧам) нь 2017 оны 6-р сарын 12-14-ний өдрүүдэд жил бүр Вашингтон хотноо зохион байгуулдаг АНУ руу хийх бизнес айлчлалыг АНУ-аас Монгол улсад суугаа Онц бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд хатагтай Женифер Зимдал Галтын удирдлага дор зохион байгуулна. Энэхүү айлчлалын бүрэлдэхүүнд Монгол Улсын Гадаад харилцааны сайд ноён Ц. Мөнх-Оргилоор ахлуулсан Монгол улсын Засгийн газрын төлөөлөгчид урилгаар оролцоно.

АНУ-Монгол Улсын хооронд бизнесийн түншлэлийг өргөжүүлэх хүчин чармайлтын хүрээнд АмЧам Монгол нь 2014 оноос хойш жил бүр уламжлал болгон энэхүү бизнес айлчлалыг зохион байгуулж байна. Энэхүү Бизнес айлчлал нь АНУ-ын болон Монголын бизнес эрхлэгчид, хөрөнгө оруулагчдад бизнесийн харилцаа тогтоох, АНУ-ын хууль тогтоох болон гүйцэтгэх засаглалын нөлөө бүхий төлөөлөлтэй хийх тусгай арга хэмжээнд оролцох, санхүүжилт эрэлхийлэх, болон Монгол Улсад Америкийн хөрөнгө оруулалтыг татах боломжийг судлах зэрэг ховор боломжуудыг олгох юм.

Бизнес айлчлалын хөтөлбөрт АНУ-ын Худалдааны Танхим, Төрийн департамент, Худалдааны яам, Хөдөө аж ахуйн яам, Эрчим хүчний яам, Худалдааны Төлөөлөгчийн Газар, Сангийн яам, Эксим банк, Төлөөлөгчдийн Танхим, Сенат болон Хилийн Чанад дахь Америкийн Хувийн Хөрөнгө Оруулалтын Корпораци зэрэг АНУ-ын төрийн болон хувийн хэвшлийн нөлөө бүхий байгууллагуудтай хийх уулзалтууд мөн Монгол Улсаас АНУ-д Суух Онц Бөгөөд Бүрэн Эрхт элчин сайд, Монголд хөрөнгө оруулах сонирхолтой хөрөнгө оруулагчид болон бусад бизнесийн төлөөлөлтэй хийх уулзалтууд орж байна.

Бизнес айлчлалын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнд Монгол улс болон олон улсын тэргүүлэх компаниудын төлөөллүүд болох Азия Пасифик Инвестмент Партнерс, Алтай Холдинг, АПУ, Би Ти ЭФ ХХК, Вагнер Эквипмент Ко, Виртус ассет менежмент, Вүүдмонт Интернейшнл, Голомт банк, Катерпиллар Инк, Магнай Трейд Групп, МахониЛиотта ХХН, Монголын Артизан Бяслэг Үйлдвэрлэгчдийн Холбоо, Оюу Толгой, Туушин Групп, Хаан банк, Хас банк, Худалдаа Хөгжлийн Банк болон Эм-Эс-Эм Групп орж байна.

Энэхүү Бизнес айлчлал нь Монгол улсын хүнсний ууган манлай үйлдвэр АПУ ХК болон судалгаа суурьтай био эмийн компани Гилейд Саянсэс Инк компаниудын ивээн тэтгэлэгтэйгээр мөн Монгол дахь АНУ-ын Элчин Сайдын Яам болон Монгол Улсын Гадаад харилцааны яамны дэмжлэгтэйгээр зохион байгуулагдаж байна.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны оффис юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.